хадгалагдахгүй, үр шимийг хүртэгч малчид, иргэд шаардлагатай арга технологид суралцахгүй бол бүлгийн үйл ажиллагаа цаашид бие даан хөгжих ирээдүйгүй болно. Иймд тэдний дунд хүний нөөцийн болон технологийн сургалтыг явуулах зайлшгүй шаардлагатай.

**Малчдын бүлэг ба засаг захиргааны хооронд харилцан итгэлцлийн харьцааг бий болгох :**

Төслийн хэрэгжилтийн явцад захиргааны байгууллага бүх бүлгүүдийн ажилд мониторинг хийж, шаардлагатай зөвлөгөө, тусламж үзүүлж байх шаардлагатай. Мониторингоор дамжуулан малчидтай санаа оноогоо нийлүүлэх боломж ихсэж, харилцан ойлголцол гүнзгийрэх ба төслийг саадгүй удирдан явуулах боломжтой болно.

# 5 МАА-н тогтолцоог сайжруулах төлөвлөгөө

## 5.1 Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежментийн төлөвлөгөө

**(Төлөвлөгөө боловсруулахтай холбоотой үндсэн үзэл баримтлал)**

**Газар зүйн Мэдээллийн Системийн мэдээллийг ашиглалт :**

Төслийн хүрээнд Газарзүйн Мэдээллийн Системийг үр дүнтэй ашиглах замаар худаг болон бэлчээрийн даацын мэдээллийг нэгтгэн авч үзэж, нийт бүс нутгийн байдлыг сайтар тодруулсны үндсэн дээр төлөвлөгөө боловсруулав. Худаг байгуулалтын үндсэн мэдээллийг 1991 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд гаргасан худгийн мэдээлэлд үндэслэн, бэлчээрийн даацын үндсэн мэдээллийн хувьд "Монгол орны бэлчээрийн чадавхи, экологийн орчин ба чанарын үнэлгээ" (МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн, 2000 он, доктор Цэрэндаш ба бусад) номыг ашиглав.

**Тогтвортой усжуулалттай бэлчээрийг тогтоосон нь :**

Бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын ажлын чиглэлийг гаргаж ирэхийн тулд усжуулалтын хувь хэмжээг тогтоох нь чухал. Иймд уст цэгээс 5 км хүртэл радиустай тойргийн хүрээг тогтвортой усжуулагдсан бэлчээр (5 км-ийн радиустай тойрог) гэж авч үзэхээр болов. Мөн энэхүү тогтвортой усжуулагдсан бэлчээрээ малын төрлөөс хамааруулан 3 км хүртэл радиустай тойрог доторхыг нь бог мал ашиглах тогтвортой усжуулалттай бэлчээр (3 км-ийн радиустай тойрог) ба бод мал ашиглах тогтвортой усжуулалттай бэлчээр (3 –5 км-ийн радиустай тойрог) хэмээн хуваан авч үзэж тогтоолоо.

**Төлөвлөгөөнд тусгагдаж буй бэлчээрийн даац ба тогтвортой усжуулагдсан бэлчээрийн хоорондын уялдаа холбоо :**

Тогтвортой усжуулалттай бэлчээр (5 км-ийн радиустай тойрог) дотор уст цэг рүү ойртох тусам бэлчээр ашиглалтын нягтрал ихэсдэг. Бод мал 3-5 км-ийн

радиустай тойргийг ашиглана гэж үзсэн боловч бодит байдал дээр 3 км-ийн радиустай тойрог доторхыг ч ашиглаж байна. Төлөвлөгөө боловсруулахдаа бэлчээр ашиглалтын дээрх бодит байдлыг харгалзан (3 км-ийн радиустай тойрог) доторх тогтвортой усжуулалттай бэлчээрийн ашиглалтын төвшинг 1 гэж үзвэл (3-5 км-ийн радиустай тойрог) доторх тогтвортой усжуулалттай бэлчээрийн ашиглалтын төвшин нь үүний 60%-тай тэнцэнэ хэмээн үзлээ.

**Усжуулалтын чадавхийн ялгаанаас хамааруулан бэлчээр ашиглалтын хувийг тогтоосон нь :**

Худгийн усжуулах чадавхи нь худгийн хүчин чадал, ойр хавийн малын тоо толгой ба бэлчээрийн чадавхиас хамааран ялгаатай байх тул бэлчээр ашиглалтын төвшинг уст цэгийнх нь төрлөөс хамааруулан өөр өөрөөр тогтоолоо.

**Тусгай хамгаалалттай газрын бэлчээр ашиглалтын асуудыг төлөвлөгөөнд тусгасан нь :**

Тусгай хамгаалалттай газрыг мал аж ахуйд ашиглахыг зарчмын хувьд хориглодог боловч бодит байдал дээр ашиглагдсаар байгаа юм. Иймд, тусгай хамгаалалттай газрыг цаашид ч одоогийн хэмжээнд ашигласаар байх боловч шинээр бэлчээр эзэмшиж, талбайн хэмжээг нэмэгдүүлэхгүй байх урьдчилсан нөхцлөөр авч үзлээ.

## 5.1.1 Бэлчээр ашиглалт, бэлчээрийн менежмент

**(Бэлчээр ашиглалт, бэлчээрийн менежментийн үндсэн чиглэл)**

Бэлчээр ашиглалтын менежмент гэдэг үүднээс бэлчээр ба усны нөөцийн тархалт, байршлын тэнцвэргүйдлийг залруулах явдал хамгийн чухал асуудал болон тавигдах юм. Үүний үндэс нь бэлчээрийн ургамлын нөөц багатай хязгаарлагдмал нөхцөл байдалтай тул улирлын чанартай отор, нүүдлийг хөхүүлэн дэмжих явдал байх юм. Нүүдлийн МАА-г тогтвортой хөгжүүлэхэд бэлчээрийн даацыг хадгалан тогтворжуулах нь чухал. Бэлчээрийн даацыг хадгалах, тогтворжуулах, улмаар сайжруулахад дараах 2 арга хэмжээг уялдуулан авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

1. Ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг усжуулж, тэдгээрийн ашиглалтыг тогтворжуулах (худаг байгуулалт)
2. Зүй зохистой усжуулалтын арга зам ба улирлын чанартай отор нүүдэл зэрэг бэлчээр ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах (усжуулалтын менежмент, бэлчээрийн менежмент)

**(Бэлчээрийн мониторингийн тогтолцоог бий болгох)**

Бэлчээрийн мониторингийг хийхэд сумын ЗДТГ голлох үүрэг гүйцэтгэнэ. Мониторингийн үндсэн үйл ажиллагаа нь бэлчээрийн нөөцийн мониторинг, бэлчээр ашиглалтын мониторинг гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

**Бэлчээрийн нөөцийн мониторинг :**

Сумын ЗДТГ-аас удирдан, малчдаар бэлчээрийн хялбар хэмжилт хийлгэж, хамтран бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг хэрэгжүүлнэ. ХАА-н түшмэл багийн дарга нарын малчдаас цуглуулсан хэмжилтийн үр дүнг нэгтгэсний үндсэн дээр бэлчээрийн даацын мэдээлэл болгож малчдад хүргэнэ.

| Малчид ба сумын захиргааны хамтарсан бэлчээрийн төлөв байдал тодорхойлох ажил | |
|---|---|
| Зорилго | Өвөлжөө, хаваржааны бэлчээрийн байдлын талаарх мэдээлэл өгөх |
| Хэнд зориулсан мэдээлэл болох | Малчид |
| Хэмжилт хийх үе | 8 – 9 сар |
| Мэдээллийг нэгтгэн малчдад буцааж хүргүүлэх үе | 10 – 11 сар |
| Мэдээллийн нарийвчлал, мэргэжлийн түвшин | Харьцангуй доогуур түвшин, сургалт шаардлагатай |
| Хэмжилтийн цэгийн тоо | Олон (30 цэгт) |
| Хэмжилт хийх газар | Сумын хэмжээнд тарүү |

**Бэлчээр ашиглалтын мониторинг :**

Сумын ЗДТГ-аас худаг байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан малчдын улирлын чанартай отор нүүдэл, уст цэг хослуулах ашиглаж буй байдлыг тодруулж, үүнийгээ бэлчээрийг даацад нь тохируулан зүй зохистой ашиглах зорилго бүхий мониторингийн мэдээлэл болгон ашиглана.

**Малын тоо толгойн зохистой хэмжээ, ба ашиглалтын балансыг тогтооход шаардлагатай үзүүлэлт :**

Орчны нөхцлийг харгалзан үзсэний үндсэн дээрх 3 км-ийн радиустай тойрог доторх малын тоо толгойн зохистой хэмжээг доорх байдалтай байна гэж үзлээ.

| Бүс нутаг | | Ургац (кг/га) | Малын тоо (х.т/км$^2$) | 1 худгийг ашиглах малын зохистой тоо (х.т.) |
|---|---|---|---|---|
| Дундговь | хойд хэсэг | 285.6 | 50.1 | 1,416 |
| | өмнөд хэсэг | 155.1 | 33.0 | 933 |
| Дорноговь | хойд хэсэг | 150.7 | 32.1 | 906 |
| | өмнөд хэсэг | 147.1 | 31.3 | 885 |
| Өмнөговь | хойд хэсэг | 122.2 | 26.0 | 735 |
| | өмнөд хэсэг | 89.8 | 19.1 | 540 |

Мал, бэлчээрийн менежментэд анхаарвал зохих зүйлийн нэг бол гадна талын 3-5км-ийн радиустай тойргийн бүсэд малаа идээшлүүлэхийн ач холбогдлыг ойлгож, энэ тойргийг малын бэлчээрт идэвхитэй ашиглах замаар мал маллагааны ур чадварыг дээшлүүлэх явдал юм. Мөн, тухайн бэлчээрт идээшлэх бод малын тоог нэмэгдүүлэх зэргээр говийн нөхцөлд тохирсон малын тооны балансыг сайжруулах арга хэмжээ авах нь 3-5км-ийн радиустай тойргийг дээд зэргээр ашиглах үр дүнтэй арга зам байх болно.

**Бэлчээрийн мониторингийн тогтолцоог бий болгохын ач холбогдол :**

Усжуулалтын хүчин чадал өсөх нь бэлчээрийн хэт ашиглалтыг араасаа дагуулах магадлалтай. Гэхдээ усалгааны (услах малын тоо толгойг хянаж зохицуулах) арга технологийг сайжруулах замаар энэхүү эрсдэлийг сааруулж болно. Ийнхүү материаллаг тал ба оюунлаг талын үйл ажиллагааг цогц нэгтгэсэн, усжуулалтын балансыг хадгалж чадахуйц бэлчээр хөгжлийн бодлоготой байх нь зүйтэй.

**(Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг худаг байгуулалттай холбоотойгоор авч үзэх шаардлага)**

Худаг байгуулалтад чиглэсэн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө нь өвөлжөө, хаваржааны орчныг сайжруулах, бага ашиглалттай ба ашиглалтгүй бэлчээрийг эзэмших гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Хэсэг тус бүрд хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь байдлаар тоймлож болно.

| | Өвөлжөө, хаваржааны орчныг сайжруулах | Бага ашиглалттай болон ашиглалтгүй бэлчээрийг эзэмших |
|---|---|---|
| Үр дүн | • Усжуулалтын чадавхи сайжрах<br>• Усалгааны арга технологи сайжрах<br>• Мал өвөлжих байгууламж сайжрах | • Отор нүүдлийн бэлчээрийн талбай нэмэгдэх<br>• Усжуулалтын чадавхи сайжрах<br>• Усалгааны арга технологи сайжрах |
| Үйл ажиллагаа | • Гар худгийг засварлах<br>• Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах<br>• Өвөлжөө, хаваржааны байгууламжийг сайжруулах<br>• Усалгааны цагийг зохицуулах, худаг ашиглах дараалал тогтоох<br>• Малчдын бүлэг байгуулах | • Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах<br>• Усалгааны туслах байгууламжийг сайжруулах<br>• Малчдын бүлэг байгуулах |

**Өвөлжөө, хаваржааны орчныг сайжруулах төлөвлөгөө :**

Уг төлөвлөгөөнд хамаарагдах талууд тус бүрийн үйл хэрэгжүүлэх ажиллагааг дараах хүснэгтэд тоймлон харуулав.

| Үйл ажиллагааны чиглэл | Малчдын бүлгийн үйл ажиллагаа | Сум, аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаа | Улс, хандивлагч доноруудын үйл ажиллагаа |
|---|---|---|---|
| Гар худаг засварлах | • Гар худаг, бетон хашлагат худаг засварлахад шаардлагатай хүн хүч гаргах | | • Гар худаг, бетон хашлагат худаг засварлахад шаардлагатай материал, ачааны машин гаргах |
| Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах | • Малчдын бүлэг байгуулах, худгийн засвар арчлалтыг хариуцах | • Малчдын бүлэг байгуулах | • Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах |
| Усалгааны цагийг зохицуулах, худаг ашиглах дараалал тогтоох | • Худаг ашиглалтын журам (усалгааны цагийг зохицуулах) гаргаж хэрэгжүүлэх | • Худаг ашиглалтын журамд зохицуулалт хийх, хяналт тавих | • Худаг ашиглалтын журам нэвтрүүлэх ажлыг зааварчлан чиглүүлэх |
| Өвөлжөө, хаваржааны байгууламжийг сайжруулах | • Малын хашаа хороо засах | | |
| | • Өвс, тэжээлийн агуулах, саравч барих | | |

**Бага ашиглалттай болон ашиглалтгүй бэлчээрийг эзэмших төлөвлөгөө :**

Уг төлөвлөгөөнд хамаарагдах талууд тус бүрийн үйл хэрэгжүүлэх ажиллагааг дараах хүснэгтэд тоймлон харуулав.

| Үйл ажиллагааны чиглэл | Малчдын бүлгийн үйл ажиллагаа | Сум, аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаа | Улс, хандивлагч доноруудын үйл ажиллагаа |
|---|---|---|---|
| • Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах<br>• Усалгааны туслах байгууламжийг сайжруулах | • Услах байгууламж барихад шаардлагатай хүн хүч гаргах<br>• Сургалтад хамрагдах | • Худгийн онгоц, усан санг төсөллөх<br>• Сургалт зохион байгуулах | • Уст цэг байгуулах<br>• Худгийн онгоц, усан сан төсөллөх ажлыг зааварчлан чиглүүлэх |
| • Малчдын бүлэг байгуулах | • Бүлгээрээ худгийнхаа засвар арчлалтыг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх тогтолцоотой болох | • Малчдын бүлгийн үйл ажиллагааг хянах, зохицуулах | • Малчдын бүлэг байгуулах ажлыг зааварчлан чиглүүлэх |

## 5.1.2 Худаг байгуулалтын ажлыг сайжруулах төлөвлөгөө

**(Худаг байгуулалтыг сайжруулах ажлын зорилго)**

Худаг байгуулалтын ажлыг хэрэгжүүлж, "одоо ашиглаж буй бэлчээрийн усжуулалтын үзүүлэлтийг дээшлүүлэх", "ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээрийг эзэмших замаар ашиглах боломжтой бэлчээрийн талбайг нэмэгдүүлэх" зорилтыг хангаж биелүүлснээр бэлчээрийн зүй зохистой ашиглалтыг бодит зүйл болгож чадна.

**(Худаг байгуулалтын ажлын үндсэн чиглэл)**

**Худаг байгуулалтын ажлыг малчдын санал хүсэлтэд үндэслэн хэрэгжүүлэх :**

Тухайн бэлчээрийг ашиглах хүсэл сонирхол малчдад байх нь худгийн тогтвортой ашиглалт, хамгаалалтын урьдчилсан нөхцөл болно. Иймд худаг байгуулалтын ажлыг ойр хавийн малчдын санал, хүсэлтэд тулгуурлан хэрэгжүүлнэ. Нөгөө талаар, сумын ЗДТГ гамшиг, эрсдэлийн нөхцөл байдлыг хянаж байх шаардлагын үүднээс худаг байгуулалтын ажлыг бүс нутгийн хэмжээнд баланстайгаар хэрэгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулж байх нь чухал.

**Худаг байгуулалтын ажлыг бэлчээрийн менежменттэй цогц байдлаар уялдуулах авч үзэх :**

Худаг байгуулалтын ажлыг бүс нутгийн хэмжээний бэлчээрийн менежментийн системд татан оролцуулах хэрэгсэл болгон идэвхитэй ашиглана. Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхэд малчдын зүгээс шаардагдах оролцоо, хамтран ажиллах чиглэлүүдийг худаг ашиглалтын гэрээнд үүрэг болгон тусгана.

**Худгийн ажилтай нэгэн зэрэг худгийн засвар, арчлалтын тогтолцоог бий болгох арга хэмжээ авах :**

Худгийг ашиглаж эхэлснээс хойш байнга арчлан хамгаалж явах шаардлагатай тул худаг гаргах ажилтай нэгэн зэрэг худгийн засвар, арчлалтын тогтолцоог бий болгоход чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

**Хуучин худгийг үр бүтээлтэй ашиглах :**

Одоогоор ашиглах боломжгүй байгаа хуучин худгуудыг засварлах нь шинээр гаргаснаас хямд тусах тул хуучин худгуудыг сэргээн засварлах ажлыг нэн тэргүүнд авч хэрэгжүүлнэ. Сэргээн засварлах боломжгүй худгуудын хувьд ус гарах магадлал өндөр байх үүднээс хуучин худгийнх нь үзүүлэлтүүдийг ашиглан дэргэд нь шинээр худаг гаргана.

**Шинээр худаг гаргах :**

Хуучин худаг ч байхгүй бэлчээрийн хувьд, түүнийг эзэмших шаардлагын үүднээс усны хайгуулаар магадлагдсан газрыг сонгон шинээр худаг гаргах ажлыг хэрэгжүүлнэ.

**Худгийн байршил(тархалт)-ын үр ашигтай байдлыг хангах :**

Шинээр гаргах буюу сэргээн засварлах инженерийн хийцтэй худгийн хувьд, уст цэг тус бүрийн эргэн тойрны 3 км-ийн радиустай тойрогт ашиглах боломжтой тогтвортой усжуулагдсан бэлчээр байна гэж үзэн одоо ашиглагдаж буй худгаас 6км-ийн зайтай байхаар байршлыг нь тогтооно.

**Ажил хийгдэх худгийг эдийн засгийн үр ашигтай талыг бодолцон сонгох нь :**

Ундарга багатай худаг дээр хангалтай хэмжээний ус өргөхөд ихээхэн цаг шаардагдана. Иймд ашиглалт ба арчилгаа хамгаалалтын зардлыг нь тооцоод үзэхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй байх тохиолдол олон байдаг. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд 0.6л/с-ийг жишиг болгон авч үүнээс бага ундаргатай худгуудыг сэргээн засварлахгүй байхаар тусгалаа. Шинээр худаг гаргах тохиолдолд усны хайгуулаар бага гүнээс ус гарахаар үнэлэгдсэн газраас худгийн ажлыг эхлүүлнэ. Ингэхдээ ойр орчмын хуучин худгууд зэргийн мэдээлэлд үндэслэн усны чанар, ундарга ямар байж болохыг харгалзан үзэж сонголт хийх юм.

**(Хэрэгжүүлэх бүтэц)**

Худаг, уст цэгийг байгуулах ажлыг 2005 оны 7 сард батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ын дагуу явуулна. Малчдын бүлгийн хүсэлтийг сумын ЗДТГ, аймгийн ХХХААГ зэрэг орон нутгийн засаг захиргааны байгууллага нэгтгэн авч, улсын төсөв болон бусад хандивлагчдын хөрөнгөөр худаг байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ. ХХААЯ-ны журмаар малчдын хүсэлтэд үндэслэн худгийг сонгосны дараа худгийг ашиглагчдад нь хүлээлгэн өгөх хүртэл 2 жилийн хугацаа шаардагдах юм байна.

**(Ирээдүйн төлөвлөгөө)**

**Худаг байгуулалтын хөгжлийн зорилтот тоо хэмжээг тодорхойлох :**

Аймгуудын бэлчээрийн өнөөгийн байдлыг үндэслэн нийт бэлчээрийг усжуулах магадлалыг харгалзан үзэж, ирээдүйн худаг байгуулалтын төлөвлөгөөний зорилтот тоо хэмжээг тодорхойлов. Бэлчээрийн байдал харьцангуй сайн хээр

ба говь-хээрийн бүсэд нийт талбайн 90% хүртэл, говийн бүсэд 70% хүртэлхийг худаг байгуулалтад хамруулах зорилт тавилаа.

**Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал ба бэлчээрийн даац :**

Уст цэгийн байршлын өнөөгийн байдалд үндэслэн тогтвортой усжуулалттай 3 км ба 5 км-ийн радиустай тойрогт тус бүр ноогдох бэлчээрийн талбай ба бэлчээрийн даацыг нэгтгэн тооцоолов.

**Худаг байгуулалтад хамрагдах бэлчээрийн талбай ба түүний даац :**

Төлөвлөгөөнд ашиглахаар тусгагдсан бэлчээрийн талбайгаас одоо ашиглагдаж буй тогтвортой усжуулалттай бэлчээрийн талбайг хасаад гарсан талбайг шинээр эзэмших бэлчээр гэж үзнэ. Энэ бэлчээрийг ашиглахад шаардагдах худгийн тоо хэмжээг худаг байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж байна.

**Төлөвлөсөн худгийн тоо :**

Нэг худаг гаргаснаар ашиглах боломжтой болох бэлчээрийн талбайн хэмжээг өнөөгийн байдлаар нэг уст цэгийн усжуулж буй бэлчээрийн талбайтай адилхан хэмжээн үзэж, төлөвлөгөөнд тусгагдах худгийн тоог тооцоолсон болно. Тогтвортой усжуулалттай 3 км-ийн радиустай тойргийн бэлчээрээр аваад үзэхэд Дундговьд 1692, Дорноговьд 2568, Өмнөговьд 3989, 3 аймагт нийтдээ 8261 газарт худаг шинээр барих шаардлагатай гэсэн тооцоо гарч байна.
Ийм тооны худгийг бүгдийг нь барихад урт хугацаа шаардагдана.

**(Худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөө)**

Судалгаанд хамрагдсан 3 аймгийн бэлчээрийн байдлыг харгалзан, бүс нутгийн бэлчээрийн даацыг үр ашигтайгаар ашиглах зорилго бүхий худаг байгуулалтын мастер төлөвлөгөөг ирээдүйн төлөвлөгөө болгон боловсруулна. Эдгээрээс чухал хэрэгцээтэй уст цэг хэмээн тооцогдох худгуудыг эхний ээлжинд байгуулах төлөвлөгөө буюу худаг байгуулалтын ажлын эхний үе шатны төлөвлөгөөг боловсрууллаа.

**Худгуудыг шинээр гаргах, сэргээн засварлахад баримтлах үндсэн чиг баримтлал :**

| Худгийн төрөл | Үндсэн чиг баримтлал |
|---|---|
| Гүний өрөмдмөл худаг | Шинээр худаг гаргах гэхээс илүү сэргээн засварлах ажлыг нэн тэргүүнд авч үзнэ. Ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг эзэмших шаардлагаар шинэ худаг гаргана. Мөн сэргээн засварлах боломжгүй худгийн дэргэд орлуулан гаргана. |
| Богино яндант худаг | Зөвхөн сэргээн засварлах боломжтой нь тогтоогдсон худгийг засварлана. Ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг эзэмших шаардлагаар шинэ худаг гаргана. Мөн сэргээн засварлах боломжгүй худгийн дэргэд орлуулан гаргана. Уурхайн худгийг ашиглах боломжгүй болсон тохиолдолд дэргэд нь орлуулан гаргана. |
| Уурхайн (бетон хашлагат) худаг | Зөөврийн насос суурилуулж, сэргээн засварлана. Шинээр байгуулах боломжгүй тул хуучин худгийн үзүүлэлтийг үндэслэн усны төвшин бага худгийг гар худгийн хэлбэрээр ашиглана. Усны төвшин гүн, ундарга арвинтай худгийн дэргэд орлуулах байдлаар богино яндант худаг гаргана. |
| Гар худаг | Хуучин тархалтыг нь эвдэх байдлаар малчдын хүчээр гар худаг гаргах, засварлах ажлыг хийнэ. Засаг захиргааны зүгээс дэмжлэг үзүүлнэ. |

## Худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөөнд тусгагдсан худгуудын тоо хэмжээ (төрөл тус бүрээр ):

| удгийн төрөл | | Дорноговь | Дундговь | Өмнөговь |
|---|---|---|---|---|
| Шинээр гаргах | Өрөмдмөл худаг | 144 | 93 | 114 |
| | Богино яндант худаг | 132 | 263 | 260 |
| | Гар худаг | 323 | 543 | 435 |
| Сэргээн засварлах | Өрөмдмөл худаг | 66 | 117 | 103 |
| | Богино яндант худаг | 26 | 52 | 71 |
| | Уурхайн худаг (насостой) | 219 | 201 | 93 |
| | Гар худаг | 300 | 375 | 350 |
| Нийт | | 1,210 | 1,444 | 1,426 |

## Худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ашиглах боломжтой болох бэлчээрийн талбай ба түүний даац :

| | | Усжуулагдсан бэлчээрийн талбай (км$^2$) | | | Бэлчээрийн талбай (1000 х.т) | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дундговь | Дорноговь | Өмнөговь | Дундговь | Дорноговь | Өмнөговь |
| Төлөвлөгөөний зорилт | | 67,007 | 90,758 | 129,185 | 2,629 | 2,824 | 2,724 |
| Одоо байгаа уст цэг | Тогтвортой усжуулагдсан бэлчээр (5км-ийн радиустай тойрог) | 62,858 | 78,688 | 106,771 | 2,148 | 1,810 | 1,780 |
| Эхний үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлсний дараа | Тогтвортой усжуулагдсан бэлчээр (3км-ийн радиустай тойрог) | 50,080 | 51,492 | 71,660 | 1,946 | 1,459 | 1,489 |
| | Тогтвортой усжуулагдсан бэлчээр (5км-ийн радиустай тойрог) | 66,805 | 85,310 | 116,084 | 2,299 | 2,045 | 2,024 |
| Үүний дараах зорилтын биелэлтийн түвшин | 3км-ийн радиустай тойрог | 75% | 57% | 55% | 74% | 52% | 55% |
| | 5км-ийн радиустай тойрог | 100% | 94% | 90% | 87% | 72% | 74% |
| Уст цэгийн тоо | | 4,017 | 2,972 | 4,307 | | | |
| 1 уст цэгт ноогдох тогтвортой усжуулалттай бэлчээрийн талбай ба түүний даац | (3км-ийн радиустай тойрог) | 12 | 17 | 17 | 0.484 | 0.491 | 0.346 |
| | (5км-ийн радиустай тойрог) | 17 | 29 | 27 | 0.572 | 0.688 | 0.470 |

5 км-ийн радиустай тойрог доторх тогтвортой усжуулалттай бэлчээрээр жишээлэн авч үзэхэд худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөө хэрэгжсэнээр төлөвлөгөөний зорилттой харьцангуйгаар Дундговьд 100%, Дорноговьд 94%, Өмнөговьд 90%-ийн үр дүн гарч, зорилт бараг бүрэн биелэгдэх юм. Бэлчээрийн даацын хувьд мөн 5 км-ийн радиустай тойрог доторх тогтвортой усжуулагдсан бэлчээрээр аваад үзэхэд төлөвлөгөөний зорилтын биелэлтийн үзүүлэлт Дундговьд 87%, Дорноговьд 72%, Өмнөговьд 74%-тай байх болно.

2004 оны байдлаарх болон зудад нэрвэгдэхээс өмнөх 1999 оны байдлаарх малын тоо толгой ба төлөвлөгөөний зорилтот бэлчээрийн даацыг харьцуулбал, Дундговь аймгийн хувьд 2004 оны малын тоо нь зорилтот бэлчээрийн даацыг 100% ашиглахаар, харин 1999 оны малын тоо нь уг бэлчээрийн даацаас хэтэрсэн байдалтай байна. Иймд энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Дундговь

аймгийн хувьд одоогийн байгаа малаа тогтвортой тэжээж хүрэлцэхүйц бэлчээртэй болох ба харин 1999 онд байсан тооны малыг тэжээхэд хүрэхгүй тул малын чанарыг сайжруулах зэрэг уст цэг байгуулалтаас өөр хэлбэрийн арга хэмжээг давхар авч явах шаардлагатай болох юм.

**Ажлын зардлын баримжаалсан тооцоо :**

Стандарт үзүүлэлтүүд :

Өрөмдмөл худгийн стандарт үзүүлэлт (техникийн тодорхойлолт)-үүдийг судалж тогтоохдоо 500 орчим толгой малыг услахад 2.5м3 ус шаардагдах ба худгийн ундарга 1.0 л/сек байх тохиолдолд 40 орчим минутад усалж дуусах тул үүнийг жишиг болгон авлаа. Тэрчлэн усан санг дээрх тооны малыг 1 удаа услахад хүрэлцэхүйц хэмжээгээр буюу 2.5 тонны багтаамжтай байхаар тооцов.

Гэхдээ олон тооны бод малтай, мал усалгаанд нэг дор их хэмжээний ус шаардагдах малчдын бүлгийн хувьд онгоцоо томгох, их багтаамжтай усан сан суурилуулах зэрэг мал усалгааны цагийг богиносгоход чиглэсэн арга замуудыг эрэлхийлэх шаардлагатай. Малчдаас хариуцах зардлаа төлөхийг шаардахаасаа илүүтэйгээр худаг ашиглагч болохынх нь хувьд тэдний санал, хүсэлтийг байгууламжийн төлөвлөлтөд тусгах шаардлагатай.

Байгуулалтын өртөг :

Туршилтын төслөөр дамжуулан хэрэгжүүлсэн худаг сэргээн засварлах, шинээр гаргах барилгын ажилд шаардагдсан өртөгт үндэслэн, худгийн төрөл тус бүрээр байгуулалтын өртгийг тооцооллоо (ам.доллар).

| Барилгын ажлын төрөл | | Байгуулалтын өртөг | Барилгын ажлын зардал | Тооцоот гүн | Тоног төх. зардал | Тооцоот гүн |
|---|---|---|---|---|---|---|
| Шинэ худаг барих | Өрөмдмөл худаг | 12,720 | 11,160 | H=100м | 1,560 | х.г.=40м |
| | Богино яндант худаг | 9,130 | 7,900 | H=20м | 1,230 | х.г.=20м |
| | Гар худаг | 200 | 200 | | | |
| Сэргээн засварлах | Өрөмдмөл худаг | 7,280 | 5,720 | H=100м | 1,560 | х.г.=40м |
| | Богино яндант худаг | 5,840 | 4,610 | H=20м | 1,230 | х.г.=20м |
| | Гар худаг | 3,580 | 2,500 | - | 1,080 | - |
| | Уурхайн худаг (насостой) | 200 | 200 | | | |

Тайлбар 1: Өрөмдмөл болон богино яндант худгууд дээр барилгын ажилд зарцуулагдсан бодит зардлыг 10% өсгөж, үүнд насосны байшин барих 2000 доллар, онгоц, усан сан барих 500 долларын зардлыг оруулсан тооцсон болно.

Тайлбар 2: Гар худгийн хувьд малчид өөрсдийн хүчээр байгуулна гэсэн нөхцлөөр тооцлоо.

Барилгын ажлын зардал :

Худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах барилгын ажлын зардал нь Дундговь аймагт 5,569,000 ам.доллар, Дорноговь аймагт 4,518,000 ам.доллар, Өмнөговь аймагт 5,409,000 ам. доллар байх тооцоо гарч байна.

## 5.1.3 Шинээр барих ба сэргээн засварлах худгуудын засвар үйлчилгээ

Шинээр барих ба сэргээн засварлах худгуудын тогтвортой ажиллагааг хангахын тулд доорх байдлаар засвар үйлчилгээний тогтолцоог бий болгоно.

**(Эзэмшигчийн хариуцлагыг сайжруулах арга хэмжээг худаг байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн хэрэгжүүлэх)**

Эзэмшигчийн хариуцлагыг сайжруулахад чиглэсэн дор дурдсан арга хэмжээнүүдийг авна. Зохион байгуулалтад оруулах эдгээр арга хэмжээнүүдийг сумын ЗДГТ-аас малчдыг уриалан хэрэгжүүлэх юм. Малчдыг зохион байгуулалтад оруулах ажлын арга туршлага, сумын ЗДТГ-ын ажилтнуудын чадвар чухал шаардлагатай.

- Малчдыг зохион байгуулалтад оруулах
- Худаг ашиглалтын гэрээ хийх
- Малчдын худгийн сан байгуулах

**(Сумын худгийн сан байгуулах)**

Худаг ашиглалтын гэрээ байгуулах нь сумын ЗДТГ-аас худаг ашиглах эрхийг тухайн малчдад өгч, засвар үйлчилгээг нь ч хариуцуулж буй хэрэг юм. Сум ба аймгийн ЗДГТ-т малчдын худгийн засвар үйлчилгээ явуулах ажлыг дэмжих төсөв байдаггүй тул тоног төхөөрөмж эвдэрсэн үед сумын ЗДТГ-аас малчдыг дэмжин туслах чадвартай байлгахын тулд сумдын ЗДТГ дээр худгийн сан байгуулах юм.

Малчдын бүлэг худгийн барилгын ажлын зардлаас өөрсдийн хариуцах хэсгээс арай ахиу мөнгийг сумын захиргаанд төлж, энэхүү илүү төлсөн хэсгээр нь худгийн санг байгуулах юм. Санг эхний ээлжинд сумын захиргаанаас ашиглалтад оруулсан худгийн сэлбэг материалыг худалдан авах, эвдэрсэн тоног төхөөрөмжийг засварлах хөрөнгө болгон ашиглана. Сумын худгийн сангийн ашиглалтыг ил тод байлгаж, сангийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд жилд 1 удаа сумын иргэдэд үйл ажиллагааны тайлан тавих үүрэг хүлээнэ.

**(Худгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тогтолцоог бий болгох)**

Худгийн тоног төхөөрөмж эвдэрсэн үед малчдын бүлэг засвар үйлчилгээг хариуцаж явах шаардлагатай. Энэ үед нь сум ба аймгийн ЗДТГ дэмжлэг үзүүлж, малчид засвар үйлчилгээгээ тогтвортой үргэлжүүлэн хийж чадахуйц тогтолцоог бий болгоно. Худгийн засвар үйлчилгээнд шаардлагатай үйл ажиллагаа нь доорх байдалтай байна.

- Малчдад тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сургалт явуулах
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хариуцсан хүнийг бэлдэх
- Суманд сэлбэг нөөцлөж, тоног төхөөрөмж нийлүүлэх тогтолцоотой болох
- Орон нутгийн худгийн компанийн дэмжлэгийг авч, хамтран ажиллах.

## 5.2 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах тухай бүрэлдэхүүн хэсэг

Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг сайжруулж, найдвартай ажиллагааг нь хангахад шаардагдах арга хэмжээ, үйл ажиллагаагаар дамжуулан, хөдөөгийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг бодит зүйл болгоход оршино.

**(Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах төсөл)**

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш мал эмнэлгийн үйлчилгээний менежмент тогтворжсонгүй. Мал эмнэлгийн тоо цөөрч, эм тариа нь ховордон, технологийн төвшин хангалтгүй байдалд ороод байгаа. Энэ байдлыг сайжруулан, мал сүргийн эрүүл мэндийг хамгаалснаар мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тогтворжуулах боломжтой болох юм.

**Хамрагдах бүлэг:** Мал эмнэлэг ба малчдын бүлэг

**Хэрэгжүүлэгч байгууллага :** Сум болон аймгийн удирдах байгууллагууд

**Төслийн зорилт :** Хөдөө орон нутаг дахь мал сүргийн эрүүл мэнд хамгаалагдана.

**Гарах үр дүн :**

- Орон нутаг дахь мал эмнэлгийн үйлчилгээний чанар сайжирна.
- Малчид болон мал эмнэлгийн хооронд хамтран ажиллах тогтолцоо бий болно. (Малчдын бүлэг байгуулагдана)
- Орон нутагт мал эмчилгээний бүтээгдэхүүн тогтвортой нийлүүлэгдэнэ.
- Малчид, малын эрүүл мэнд, эрүүл ахуйн талаар анхан шатны мэдлэгтэй болно.

**Хөрөнгө оруулалт :**

Мал эмнэлгийн сургалт, малчдад зориулсан сургалт, мал эмчилгээний бүтээгдэхүүн, сумын мал эмнэлгийн байгууламж, материал тоног төхөөрөмж.

**(Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх төсөл)**

Шилмэл мал оруулж ирдэггүй, эцэг малаа ойроос сонгодгоос малын чанар муудсан байна. Тооноос чанарт шилжиж, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэхэд уг төслийн зорилго оршино.

**Хамрагдах бүлэг:** Малчид

**Хэрэгжүүлэгч байгууллага :** Сум болон аймгийн удирдах байгууллагууд

**Төслийн зорилт :** Шилмэл үүлдрийн малын тоо толгойг олшруулах.

**Гарах үр дүн :**

- Шилмэл үүлдрийн малыг үржүүлэн олшруулах (түгээн дэлгэрүүлэх) тогтолцоо сайжирна.
- Мал үржүүлгийн мэдлэг, арга технологи сайжирна(малын эмч нарын).
- Мал үржүүлэх талаарх малчдын мэдлэг, арга ажиллагаа сайжирна.

**Хөрөнгө оруулалт :**

Малжуулах сангийн үндсэн хөрөнгийг шилмэл үүлдрийн малаар бүрдүүлэх, малын эмч, малчдад зориулсан сургалт явуулах.

**(Мал маллагааны арга технологийг сайжруулах төсөл)**

Нэгдлийг татан буулгасны дараа тэнд ажиллаж байсан албан хаагчдаас олон хүн ажилгүй болсны улмаас мал дээр гарч, мал мэдэхгүй малчдын тоо өссөн байна. Иймд нөхцөл байдлын дунд мал маллах үндсэн арга ажиллагаанд малчдыг сургаж, үйлдвэрлэлийн технологийг нь сайжруулах шаардлага гарч байна.

**Хамрагдах бүлэг:** Малчид

**Хэрэгжүүлэгч байгууллага :** Сум болон аймгийн удирдах байгууллагууд

**Төслийн зорилт :** Хөдөө орон нутгийн малчдын мал маллагааны арга ажиллагааг сайжруулах.

**Гарах үр дүн :**

- Мал маллагааны арга туршлага багатай малчдын тоо цөөрнө. (Малчин нь малчнаа сургах сургалт явуулах)
- МАА-н үйлдвэрлэлийн үндсэн технологи сайжирна.
- Малчдын МАА эрхлэх менежментийн үндсэн мэдлэгт суралцана.

**Хөрөнгө оруулалт :**

МАА-н технологийн сургалтад багшлах, хамрагдах малчдын сургалтын зардал, МАА-н үйлдвэрлэлийн анхан шатны технологийн гарын авлага зохиох, түүгээр сургалт явуулах зардал, малчин өрхийн аж ахуйн менежментийн гарын авлага зохиох, түүгээр сургалт явуулах зардал.

**(Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх төсөл)**

Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог боловсронгуй болгож, хөгжүүлэн авч явахын тулд мал аж ахуйд тохиолдох төрөл бүрийн эрсдэлийг бууруулж, түүнийг тогтвортой мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбож өгөх шаардлагатай билээ.

**Хамрагдах хэсэг:** Сум болон аймгийн удирдах байгууллагууд

**Төслийн зорилт :** Хөдөөд тохиолдох гамшгийг даван туулах, өвчнөөс сэргийлэх чадавхийн хувьд улам бэхжсэн мал аж ахуйн тогтолцоог бий болгох.

**Гарах үр дүн :**

- Тэжээлийн нөөц бүрдүүлэх систем тогтоно.
- Малын хашаа хороо сайжирна.
- Малын даатгалын тогтолцоо сайжирна.
- Цаг агаарын мэдээ, урьдчилан сэрэмжлүүлэх тогтолцоо сайжирна.
- Малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний үзлэг шалгалт хийх тогтолцоо сайжирна.
- Малын хулгайн гэмт хэргийн гаралт буурна.

**Хөрөнгө оруулалт :**

Нөөц тэжээл худалдан авах зардал, хашаа хороо засаж сэлбэх, шинээр барих зардал, цаг агаарын урьдчилан сэрэмжлүүлэх мэдээллийн сүлжээг сайжруулах зардал, мал угаалгын онгоц барих, сэргээн засварлах зардал.

## 5.3 Малчин өрхийн орлогыг тогтворжуулах бүрэлдэхүүн хэсэг

Зах зээлд шилжсэнээр малчдын бэлэн мөнгөний шаардлага нэмэгдсээр буй авч тэд төдий хэмжээний орлогыг олж чадахгүй, орлого олох боломжийн хувьд ч хязгаарлагдмал байгаа тул орлогын шинэ эх үүсвэр бий болгох шаардлага тулгарч байна.

**(Мал аж ахуй эрхлэлтийн менежментийг сайжруулах төсөл)**
Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар орон нутгийн малын гаралтай бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлж, төслөөр дамжуулан орлого олох, бизнес эрхлэх боломжийг олгож, малчид болон хөдөөгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэхийг зорино.

**Хамрагдах бүлэг:** Малчид

**Хэрэгжүүлэгч байгууллага :** Сум болон аймгийн удирдах байгууллагууд

**Төслийн зорилт :** Малчид, хөдөөгийн иргэд мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэрлэл эрхэлж эхлэх.

**Гарах үр дүн :**

- Орон нутгийн иргэд, малчид мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах арга технологийг эзэмшинэ.
- Орон нутгийн иргэд, малчид эдийн засгийн мэдлэгтэй, биенес эрхлэх чадвартай болно.
- Мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсуулах жижиг үйлдвэрлэлийн биенесийг санхүүжүүлэх тогтолцоо сайжирна.

**Хөрөнгө оруулалт :**

Малчид, иргэд мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах жижиг бизнес эхлүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, санхүүжилтэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, боловсруулах технологийн мэргэжилтэн. Эдийн засаг менежментийн мэргэжилтэн, танилцах айлчлал (уг төрлийн ажлыг эрхэлж буй газруудад очиж суралцах)

**(Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах төсөл)**

Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнээ зах зээлд шууд нийлүүлэхэд шаардагдах дэд бүтцийг сайжруулах болон хүний нөөцийн сургалтыг явуулах юм.

**Хэрэгжүүлэгч байгууллага :** Сум, аймгийн захиргаа, улс.

**Төслийн зорилт :** Орон нутгийн мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийг

өргөжүүлэх.

**Гарах үр дүн :**

- Зах зээлтэй болно. (Орон нутагт худалдаа арилжаа явуулах зах зээл болон түшиц газруудыг хөгжүүлэх)
- Малчид, иргэд зах зээлтэй холбоотой мэдлэгийг эзэмшинэ. (Малчид зохион байгуулалтад орох, бүтээгдэхүүнээ хамтарч борлуулах, хоршсон бизнес эрхлэх)
- Зах зээлийн дэд бүтэц сайжирна. (Зам тээвэр, цахилгаан, холбоо, төмөр зам гэх мэт)
- Зах зээлийн мэдээллийн ашиглалт сайжирна.

**Хөрөнгө оруулалт :**

Эдийн засгийн зөвлөх мэргэжилтэн, төрөл бүрийн бүтээгдэхүүн боловсруулах мэргэжилтнүүд, сургалт явуулах газар, нийгмийн дэд бүтцийг сайжруулах.

## 5.4 Хүний нөөцийг хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг

Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, менежмент, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах, малчин өрхийн орлогыг тогтворжуулах гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс гарах үр дүн, өгөөжийг төгөлдөржүүлэхэд хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх явдал зайлшгүй чухал.

**Хамрагдах бүлэг:** Малчид, иргэд, сум, аймгийн захиргааны ажилтнууд.

**Төслийн зорилт :** Хөдөөд мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд оролцогчдын чадавхи сайжирна.

**Гарах үр дүн :**

- Орон нутгийн засаг захиргааны байгууллага малчид, иргэдийн зохион байгуулалттай үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой болно.
- Малчид, иргэд зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулах чадвартай болно.
- Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, технологийг удирдах ажилтнууд олж авна.
- Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, технологийг малчид иргэд эзэмшинэ.

**Хөрөнгө оруулалт :**

Хөдөөгийн мал аж ахуйн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн сургалт, гарын авлага гаргах зардал, малчид, иргэдийг хамруулах төлөвлөгөө боловсруулах сургалтын зардал.

## 5.5 Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө

**(Төслийн агуулга ба тэргүүлэх дараалал)**

"Бэлчээрийн ашиглалт, худаг байгуулалт, менежмент" нь хөдөөгийн МАА-н тогтолцоог сайжруулах төлөвлөгөөний нэн тэргүүний, суурь төсөл юм. Бусад төслүүдийн хувьд "Бэлчээрийн ашиглалт, худаг байгуулалт, менежмент"-ын төслийг иж бүрэн болгох нэмэлт төслүүд бөгөөд хөдөөгийн мал аж ахуйн хувьд чухал ач холбогдолтой, эдгээр төслүүдийг эн тэгш зэрэгцүүлэн урагшлуулж явбал бүх төслүүдээс цогц нэгдмэл үр дүн гарах юм.

**(Төлөвлөгөөний нарийн тодорхой байдал)**

**Худаг байгуулалт, менежментийн төсөл :**

Худаг байгуулалт, менежментийн төлөвлөгөөн дэх худагтай холбоотой суурь мэдээллүүдийн нарийн тодорхой байдлын тухайд, туршилтын судалгаа хэрэгжүүлсэн 3 сумд, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулсан Дорноговь аймаг, тэрчлэн бусад 2 аймгуудын хувьд ч хоорондоо харилцан адилгүй байна. Иймд уг төлөвлөгөөг туршилтын судалгаа хэрэгжүүлсэн сумдаас өөр газарт хэрэгжүүлэх бол худгуудын мэдээлэл (худгуудын тухай мэдээ, баримт, тэдгээрийг сэргээн засварлах боломж)-ийг шалгаж үзэх зайлшгүй шаардлагатай.

**Боловсруулах бичил төслүүд :**

Эдгээр төслүүд нь агуулгын хувьд орон нутгийн онцлог ба хэрэгжүүлэгчдийн санаа зоригоос шалтгаалан ялгаатай байж болно. Гэхдээ төслийн бүтэц зохион байгуулалтын хувьд "4-р бүлэг. Туршилтын төслийн судалгаа" гэсэн хэсэгт дүйцүүлэн хэрэгжүүлэх боломжтой.

**(Худаг байгуулалт, менежментийн төслийн бэлтгэл ажил)**

Худаг байгуулалт, менежментийн төслийг хэрэгжүүлэхийн тулд "Худаг байгуулалтын процесс"-т үзүүлсний дагуу малчдыг зохион байгуулалтад оруулах ажлыг эхлүүлэх шаардлагатай. Ингэхдээ аймгаас бүх сумдад худаг байгуулалтын ажлын чиглэлийг өгч, сумд түүний дагуу сумынхаа худаг байгуулалтын ажлын чиглэлийг гаргаж, малчдад өргөн зарлан мэдээлэх ба худагтай болох хүсэл бүхий малчид бүлэг байгуулан худгийн барилгын ажлын зардлаас өөрсдийн төлөх хэсгийг хуримтлуулж эхлэх юм.

**(Төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай болох тухайд)**

**Барилгын ажилд шаардагдах хугацаа :**

1 суманд 100 орчим цэгт худаг сайжруулахаар төлөвлөгдсөн байгаа ба үүнээс барилгын ажлын явцад нөлөөлөх нь инженерийн хийцтэй худаг болно. Инженерийн худаг байгуулахын хувьд малчдыг 100% зохион байгуулалтад оруулах нь бэрхшээлтэй тул зохион байгуулалтын хувь хэмжээг 80%, өрөмдлөгийн төхөөрөмжийг жилд ажиллуулах хугацааг 4-өөс 10-р сарууд буюу 7 сарын хугацаанд гэж тооцоолloo. Өрөмдлөгийн төхөөрөмжийн дундаж хүчин чадлаас,

аймаг тус бүр дэх барилгын ажилд шаардлагатай нийт хугацааг тооцоолон гаргавал Дундговьд 28.3 жил, Дорноговьд 21.5 жил, Өмнөговьд 27.7 жил тус тус шаардагдахаар байна.

1 гүйцэтгэгч байгууллага өрөмдлөгийн төхөөрөмж 2-3 –ыг ашиглан, нийт 5 жилд ажлыг багтаан дуусгахаар тооцвол аймаг бүрт 2-3 барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага ажиллахаар байна.

**Барилгын ажлыг үе шаттайгаар гүйцэтгэх :**

1 суманд дунджаар 30-40 инженерийн хийцтэй худаг байна. 1 суманд жилд 40 цэгт худгийн ажил гүйцэтгэх нь маш бэрхшээлтэй тул 1 суманд 2-3 жилийн хугацаанд энэхүү ажлыг хэрэгжүүлэх юм. Аймаг бүр 14-15 сумтай, 3-4 сумыг 1 бүлэг болгон ажлын талбарт хувааж, 1 аймаг дахь барилгын ажлыг 5 жил орчим хугацаанд дуусгахаар байна.

Мөн, барилгын ажлыг 3 аймагт зэрэг явуулахад ажлын хэмжээ хэт ихсэж, төслийн менежментийн тал дээр бэрхшээлтэй болох талтай, мөн барилгын ажлын зардлаас худаг ашиглагчдаар төлүүлэх гэсэн шинэ систем нэвтрүүлэн туршиж ажиллангаа ажлыг бүрэн гүйцэд хэрэгжүүлэх шаардлагатай тул аймаг тус бүр дэх ажлыг үе шатчилан хэрэгжүүлэх нь зүйтэй. Нарийвчилсан төлөвлөгөөнд хамрагдсан бүс нутаг болох Дорноговь аймагт худаг байгуулалтын ажлыг эн тэргүүний ээлжинд хийж гүйцэтгэх нь бодит сонголт болно гэж үзэж болно.

**(График төлөвлөгөө (Төслийн мөчлөг Project Cycle))**

Дээрх ажлыг хэрэгжүүлэх график төлөвлөгөөг говийн бүс нутгийн цаг агаарын нөхцөлд тохируулах төлөвлөх шаардлагатай. 1 жил доторх барилгын ажлын явагдах хугацаа хязгаарлагдмал тул энэхүү хугацааг дээд зэргээр ашиглаж, тендер, гэрээний ажлыг өвлийн улиралд хэрэгжүүлнэ. 1 аймагт 5 жилд багтаан барилгын ажлыг дуусгахаар төлөвлөнө.

**(Худгийн төслийн явц ба ажил үүргийн хуваарь)**

Худгийн төслийг эхлүүлснээс хойш ашиглаж эхлэх хүртэлх хугацаанд малчид, орон нутгийн захиргаа, улс буюу хөрөнгө оруулагч донорууд хуваарийн дагуу тус бүрт ноогдох ажил үүргийг гүйцэтгэх шаардлагатай.

Туршилтад хамрагдсан 3 сумдын хувьд туршилтын судалгаагаар дамжуулан төслийн агуулга, судалгааны зорилгыг сайтар ойлголт өгсөн хэдий ч бусад сумдын тухайд хязгаарлагдмал мэдээлэл өгсөн төдийгөөр хязгаарлагдаж байсан тул төслийн агуулга ба хэрэгжүүлэх арга замын тухай бүрэн танилцуулж, сумдын ойлголтыг гүнзгийрүүлэх шаардлагатай.

Уг төсөл нь худаг байгуулалтыг bottom up /доороос санал дэвшүүлэх/ хэлбэрээр урагшлуулах ажил тул худгийн барилгын ажлыг эхлүүлэх хүртэлх процесс чухал үүрэгтэй. Малчид, худаг ашиглах бүлгийг өөрсдөө байгуулж, ажил үүргийнхээ

хуваарийг тогтоон, засвар үйлчилгээний санг байгуулж, барилгын ажлын зардлын тодорхой хэсгийг хариуцах нь "худагт барилгын ажлыг эхлүүлэх" урьдчилсан нөхцөл юм.

Аймгийн нутаг дэвсгэр өргөн уудам тул бүх сумдад судалгаа ба барилгын ажлыг нэгэн зэрэг эхлүүлнэ гэдэг бэрхшээлтэй. Иймд нийт нутгийг 3 блокод хувааж, 1 блокийн ажлыг дуусгаад дараагийнх руу нь шилжин орох байдлаар бус 2-3 удаагийн эргэлтээр ажлыг дуусгах хэлбэрээр ажлын төлөвлөгөөг гаргаж, төсөл аймгийг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй байхаар байлгах явдал чухал .

**(Боловсруулах бичил төслүүдийн явц ба ажил үүргийн хуваарь)**

Худгаас бусад төслүүдийн хувьд ч гэсэн малчид, орон нутгийн засаг захиргаа болон улс, донорууд тус бүр тухайн төсөлд гүйцэтгэх өөрсдийн ажил үүргийг хуваарийн дагуу хэрэгжүүлэх нь чухал. Малчдын техник, технологийн түвшин, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан төслийг сонгон шалгаруулж явах нь чухал юм.

## 6. Дүгнэлт, зөвлөмж

**(Худаг байгуулалтын ажлыг түргэвчлэн хэрэгжүүлэх шаардлага)**

Усны нөөц нь гол төлөв газрын доорхи усаар тодорхойлогддог "говийн" тухайд худаг бол хүмүүсийн төдийгүй мал сүргийн оршин тогтнохын үндэс суурь юм. Мал сүргийг найдвартай бэлчээрээр ханган авч явахад засаг захиргааны байгууллагуудын оролцоотойгоор алсын хараатай бэлчээр ашиглалт, худаг байгуулалтын ажлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Бэлчээр ашиглалт, худаг байгуулалт, ашиглалтын төлөвлөгөөг бэлчээрийн нөөц ба газар доорх усны нөөц бололцоонд тулгуурлан, ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээрийг эзэмших, худгийг үр бүтээмжтэй ашиглах үүднээс боловсруулагддаг. Эдгээр төлөвлөгөөг түргэвчлэн хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Засгийн Газраас холбогдох байгууллагуудад тодорхой чиглэл өгөх нь зүйтэй гэж зөвлөж байна.

**(Худгийн ашиглалт, засвар үйлчилгээ чухал болох тухай)**

Инженерийн хийцтэй худагт тавьсан насос, мотор нь ашиглалтын тодорхой хугацаатай учраас гамтай ашиглахгүй бол аажимдаа муудсаар цагаасаа өмнө эвдэрч ажиллахгүй болдог. Түүнээс гадна эвдэрсэн худгийн тоног төхөөрөмжийг засварлах боломж суманд байхгүй, буцаагаад үйлдвэрлэсэн газар луу нь юм уу Улаанбаатарт хүргүүлж засуулах болно. Гэтэл говийн бүс алслагдсан учраас тээвэрлэж хүрэх, засуулахад ихээхэн цаг орохын дээр зардал ч нэлээд гарна.

Ийнхүү ялангуяа алслагдсан говийн бүс нутгийн хувьд худгийн засвар арчлалтын асуудал онц чухал байдаг. Холбогдох хүмүүсийн хувьд худаг барих ажилд

анхаарал хандуулж буй хэдий ч барилгын ажил, засвар арчлалтын ажлыг цогц байдлаар авч үзэх нь зүйтэй.

**(Бэлчээрийн менежмент, худаг сэргээн сайжруулах арга хэмжээг говийн бүсийн онцлогт тохируулан явуулах тухай)**
Цаг уурын хэлбэлзэл ихтэй говийн бүс нутагт бэлчээрийн байдал жил бүр өөрчлөгддөг тул малчид сайжруулсан худгийнхаа ойр орчны бэлчээрийг жил бүр тогтвортой ашиглаж чадалгүй, малаа авч худгаасаа холдож нүүх магадлал ихтэй. Ийм учраас малчдын 1 бүлэг өөрийн эзэмшиж буй худгаасаа гадна ялангуяа яаралтай шаардлага гарсан үед бусад малчдын бүлгүүдийн эзэмшилд буй худгийг ч гэсэн саадгүй ашиглаж чадахаар байхын тулд эдгээр худаг эзэмшигч бүлгүүд хоорондоо худаг ашиглах хэлэлцээ байгуулах маягаар өргөн уудам бүс нутгийн худаг ашиглалтыг нийтэд нь хянах тогтолцоо хэрэгтэй. Эдгээр худгуудын ашиглалтыг зохицуулах газар нь зөвхөн сумын ЗДТГ байх юм.

**(Говийн бүс нутгийн бэлчээрийг өмчлүүлэх асуудлын талаар)**
